



“Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн  
ТУЗ-ийн 2016 оны 01 сарын 07-ны өдрийн  
01 тоот тогтоолын хавсралт 5

## МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монголын үнэт цаасны бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-д үнэт цаас бүртгүүлсэн үнэт цаас гаргагч болон Биржийн гишүүн компани (цаашид “гишүүн компани” гэх) хууль тогтоомж, Биржээс тогтоосон дүрэм журам, Биржтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Биржийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд дотоод хяналттай холбоотой журмыг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) батална.
- 1.3. Хяналт шалгалтын үйл ажиллагааг Биржийн хяналтын асуудал хариуцсан алба (цаашид “Хяналт хариуцсан алба” гэх) Биржийн бусад холбогдох албатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.4. Бирж мэдээлэл авах болон шалгалт хийх гэсэн хоёр төрлөөр хяналтыг хэрэгжүүлнэ.
- 1.5. Энэхүү журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг ТУЗ батална.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ

- 2.1. Бирж үнэт цаасны бүртгэлтэй холбоотой дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлнэ:
  - 2.1.1. Үнэт цаасыг Биржид бүртгүүлэхээр өргөдөл гаргагч этгээд болон үнэт цаасанд тавигдах шаардлагын хэрэгжилт;
  - 2.1.2. Бүртгэлийн баримт бичигт тавигдах шаардлагын хэрэгжилт;
  - 2.1.3. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагын хэрэгжилт;
  - 2.1.4. Биржийн тухай бүр тогтоосон нэмэлт шаардлагын хэрэгжилт;
  - 2.1.5. Мэдээллийг ил тод болгох шаардлагын хэрэгжилт.
- 2.2. Үнэт цаас гаргагч болон бүртгэлтэй үнэт цаасанд тавих хяналтын асуудлыг “Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журам” (цаашид “Бүртгэлийн журам” гэх)-аар зохицуулна.
- 2.3. Бирж үнэт цаасны арилжаатай холбоотой дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлнэ:
  - 2.3.1. Ханшийн хэлбэлзэл, өдөр тутмын үнэт цаасны арилжаанд тавих хяналт;
  - 2.3.2. Хэлцэл өөрчлөх болон цуцлах үйл ажиллагаанд тавих хяналт;
  - 2.3.3. Зах зээл үүсгэгчийн эрх үүргийн хэрэгжилт;
  - 2.3.4. Зах зээлийг урвуулан ашиглахтай холбоотой зөрчилд тавих хяналт;
- 2.4. Бирж үнэт цаасны тооцооны үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлнэ:
  - 2.4.1. Маржин, барьцаатай холбоотой үйл ажиллагаанд тавих хяналт;
  - 2.4.2. Тооцооны гишүүний үйл ажиллагаанд тавих хяналт;
  - 2.4.3. Зээлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт;

- 2.4.4. Төлбөрийн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт;
- 2.4.5. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналт.
- 2.5. Бирж гишүүнчлэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлнэ:
  - 2.5.1. Төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, санхүүгийн үзүүлэлтэд тавигдах шаардлагын хэрэгжилт;
  - 2.5.2. Боловсон хүчин, удирдлагад тавигдах шаардлагын хэрэгжилт;
  - 2.5.3. Программ хангамж, техникийн шаардлагын хэрэгжилт;
  - 2.5.4. Хавсаргах баримт бичгийн бүрдэлд тавих хяналт;
  - 2.5.5. Гишүүнчлэлийн журам, гишүүнчлэлийн гэрээнд тусгасан эрх үүргийн хэрэгжилтэд тавих хяналт.
- 2.6. Дотоод мэдээлэл эзэмшигчдийн арилжаанд тавих хяналттай холбогдуулан дотоод мэдээлэл эзэмшигчдийн сан бүрдүүлэх, хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, арилгах ажлыг хэрэгжүүлнэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ** **МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ**

- 3.1. Бирж энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасан шалгалт хийхээс бусад тохиолдолд мэдээлэл хүлээн авах замаар хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.2. Энэхүү журмын 3.1-д заасан мэдээллийн жагсаалтад Биржийн бусад журмаар тогтоосон тогтмол ирүүлэх мэдээлэл багтана.
- 3.3. Биржийн Гүйцэтгэх захирал (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) эсхүл Хяналт хариуцсан албаны захирал энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан чиглэлээр хуулиар нууцлахаар зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг тодорхой хугацааны дотор Биржид ирүүлэх тухай шаардлагыг гишүүн компанид хүргүүлнэ.
- 3.4. Энэхүү журмын 3.2, 3.3-т заасан шаардлагыг хүлээж авсан этгээд тогтоосон хугацаанд шаардсан мэдээллийг Биржид хүргүүлэх үүрэгтэй. Мэдээллийг цахимаар болон цаасан хэлбэрээр ирүүлж болно.
- 3.5. Бирж ирүүлсэн мэдээллийг албан ёсоор бүртгэн хүлээж авах ба нийтэд мэдээлэх шаардлагатай тохиолдолд өөрийн вэб сайтад байршуулж болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** **ШАЛГАЛТ ХИЙХ**

- 4.1. Биржийн шалгалт хийх үйл ажиллагаа (цаашид “шалгалт” гэх) нь ээлжит болон ээлжит бус гэсэн хэлбэртэй байна.
- 4.2. Бирж ээлжит шалгалтыг гишүүн компанитай тохиролцсоны үндсэн дээр жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хийнэ. Шалгалтын хуваарийг Гүйцэтгэх захирал батална.
- 4.3. Ээлжит бус шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:
  - 4.3.1. Биржид иргэн, хуулийн этгээдээс тухайн гишүүн компанийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол ирсэн ба Бирж уг өргөдөл, гомдлыг шалгах шаардлагатай гэж үзсэн;
  - 4.3.2. Энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу Биржээс шаардсан мэдээлэл, баримт бичгийг гишүүн компани зохих журмын дагуу ирүүлээгүй, мэдээлэл ирүүлэхээс татгалзсан, зайлсхийсэн;
  - 4.3.3. Гишүүн компанийн үйл ажиллагаанд шалгалт хийх шаардлагатай гэж Түүг үүс чиглэл үсэн.

- 4.4. Ээлжит бус шалгалт хийх шийдвэрийг Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр гаргана.
- 4.5. Ээлжит шалгалтыг иж бүрэн байдлаар, ээлжит бус шалгалтыг зөвхөн тухайн өргөдөл, гомдол болон шалгах шаардлагатай асуудлын хүрээнд хийнэ.
- 4.6. Ээлжит болон ээлжит бус шалгалтыг Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд удирдамжид дараах зүйлсийг тусгана:
  - 4.6.1. Он, сар, өдөр, удирдамжийн дугаар;
  - 4.6.2. Шалгалт хийх үндэслэл, зорилго;
  - 4.6.3. Шалгалтын арга, хэлбэр;
  - 4.6.4. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгжийн нэр;
  - 4.6.5. Шалгалт явуулах эрх бүхий этгээд;
  - 4.6.6. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа;
  - 4.6.7. Бусад шаардлагатай мэдээлэл.
- 4.7. Шалгалт хийх тухай шийдвэрийг шалгалт эхлэхээс ажлын 3 (гурван) өдрийн өмнө шалгуулагч этгээдэд хүргүүлнэ.
- 4.8. Шалгалт эхлэхээс өмнө шалгуулагч этгээдийн удирдлага, холбогдох албан тушаалтанд шалгалтын удирдамжийг заавал танилцуулна.
- 4.9. Шалгалт хийх тухай тушаал болон удирдамжийг хүлээн авсан аж ахуйн нэгжийн удирдлага Биржийн шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.
- 4.10. Шаардлагатай тохиолдолд, Бирж Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-той хамтарсан хяналт шалгалт зохион байгуулж болно.
- 4.11. Гишүүн компани нь шалгалт хийлгэхээс татгалзсан, эсхүл шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд энэхүү журмын 6 дугаар бүлэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 4.12. Шалгалтыг явуулахаар Биржээс томилсон эрх бүхий этгээд ажлын үнэмлэх, удирдамжийн эх хувийг үзүүлснээр шалгуулагчийн ажлын байранд нэвтэрч шалгалтыг эхлүүлнэ.
- 4.13. Шалгалтын явцад шалгуулагчийн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч болно.
- 4.14. Шалгалтын төгсгөлд шалгалт хийсэн тэмдэглэлийг 2 (хоёр) хувь үйлдэн, шалгуулагчийн төлөөлөгчид танилцуулж гарын үсэг зуруулна.

#### **ТАВДУГААР БҮЛЭГ** **ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЛБАНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1. Хяналт хариуцсан алба дараах эрхтэй байна. Үүнд:
  - 5.1.1. Шалгалтын ажилд зайлшгүй шаардлагатай баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;
  - 5.1.2. Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар хөндлөнгийн аудит хийлгэхийг гишүүн компаниас шаардах;
  - 5.1.3. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан энэхүү журмаар зөвшөөрөгдсөн хариуцлага хүлээлгэх;
  - 5.1.4. Илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр гишүүн компанид хугацаатай албан даалгавар өгөх;
  - 5.1.5. Шалгалтын ажлын үр дүнг үндэслэн Биржийн үндсэн үйл ажиллагааны журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал гаргах.
- 5.2. Хяналт хариуцсан алба дараах үүрэгтэй байна. Үүнд:
  - 5.2.1. Шаардлагатай батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах;
  - 5.2.2. Шаардлагатай тохиолдолд гишүүн компанид хийх шалгалтыг Хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулж гүйцэтгэх;

- 5.2.3. Илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр гишүүн компанид өгсөн албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих;
  - 5.2.4. Гишүүн компанийн үйл ажиллагаанд Биржийн дүрэм журмын хүрээнд хяналт тавих;
  - 5.2.5. Шалгалтыг гүйцэтгэх явцад хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллах;
  - 5.2.6. Шалгалтыг мэргэжлийн төвшинд үнэн зөв, шударгаар гүйцэтгэх;
  - 5.2.7. Шалгуулагч этгээдтэй сонирхлын зөрчилтэй тохиолдолд шалгалтын ажилд оролцохоос татгалзах;
  - 5.2.8. Шалгалттай холбоотой мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг чанд хадгалан, бусдад задруулахгүй байх;
  - 5.2.9. Шалгалтын тайлан, дүгнэлтийг хугацаанд нь гаргаж, удирдлагад танилцуулах.
- 5.3. Хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй этгээд нь зөвхөн өөрт олгогдсон эрх хэмжээ, удирдамжид заасан чиг үүргийн хүрээнд ажиллана.

### ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА

- 6.1. Бирж гишүүн компанид дараах тохиолдолд хариуцлага тооцно. Үүнд:
- 6.1.1. Гишүүнчлэлийн журмын шаардлагыг хангахгүй болсныг мэдсэн боловч энэ тухай Биржид мэдэгдээгүй;
  - 6.1.2. Холбогдох журам болон гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг хугацаанд нь гүйцэтгээгүй;
  - 6.1.3. Холбогдох журам болон гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүрэг, ногдуулсан торгуулийг төлж барагдуулах чадваргүй болсон;
  - 6.1.4. Төлбөрийн чадваргүй болсныг нуун дарагдуулж, арилжаанд оролцсон;
  - 6.1.5. Хуурамч арилжаа хийх, үнэ ханшийг зохиомлоор тогтоон барих, өсгөх бууруулах, зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл хийсэн;
  - 6.1.6. Аливаа этгээдэд дараах байдлаар үнэт цаас худалдаж авах, худалдахад нөлөөлсөн, нөлөөлөхийг завдсан:
    - 6.1.6.1. Чухал мэдээллийг хууль бусаар, санаатайгаар нуун дарагдуулсан;
    - 6.1.6.2. Хариуцлагагүй, шударга бусаар аливаа мэдэгдэл, амлалт, таамаглал гаргах, нийтлэх, эсвэл гаргах, нийтлэхэд хүргэсэн;
    - 6.1.6.3. Төөрөгдөл үүсгэхээр эсвэл хуурамч мэдээллийг аливаа электрон, механик болон бусад хэрэгсэлд буулгасан;
  - 6.1.7. Биржийн дүрэм журмыг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан гишүүн компанид туслалцаа үзүүлсэн, нуун дарагдуулсан эсвэл уг этгээдтэй тохиролцооны арилжаа хийсэн;
  - 6.1.8. Үнэт цаастай холбоотой хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй гэж Биржийн зүгээс зарласан эсвэл энэ тухай гишүүн компанид мэдэгдсэн аливаа хувь хүн, байгууллагатай захиалгын гэрээ байгуулсан;
  - 6.1.9. Үнэт цаасны үнэд нөлөөлөхүйц зах зээлийн мэдээлэл эсвэл нөхцөл байдлын талаар зориудаар худал, төөрөгдөлд оруулах эсвэл алдаатай тайлан гаргасан;
  - 0.1.10. Биржийн эрх бүхий албан тушаалтан, арилжаа хянагч болон бусад холбогдох ажилтанд хуурамч мэдээлэл өгсөн;

- 6.1.11. Биржээс томилсон ажилтан, арилжаа хянагчийн шалгалтын үйл ажиллагааны үеэр олж авсан нууц мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашигласан эсвэл задруулсан;
  - 6.1.12. Биржийн эрх бүхий албан тушаалтанд үйл ажиллагаа явуулдаг өөрийн бүртгэлтэй бизнесийн албан ёсны хаяг болон бусад байршилд нэвтрэх эрх олгох, шаардсан баримт бичиг, тайлан, мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан;
  - 6.1.13. Зөрчлийг хэлэлцэх хурал, хяналт шалгалтын үеэр асуусан асуултад бүрэн хариулах, шаардлагатай тайлан, баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалзсан, эсвэл худал мэдүүлэг өгсөн;
  - 6.1.14. Өгсөн албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй;
  - 6.1.15. Гишүүнээр элсэх үед хуурамч баримт бичиг бүрдүүлэн ирүүлсэн.
- 6.2. Гишүүн компани, түүний холбогдох этгээдэд Бирж дараах хариуцлага тооцно. Үүнд:
- 6.2.1 Хаалттай сануулах;
  - 6.2.2 Нээлттэй сануулах;
  - 6.2.3 Хугацаатай албан даалгавар өгөх;
  - 6.2.4 Гишүүнчлэлийн гэрээнд заасны дагуу торгууль ногдуулах;
  - 6.2.5 Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх;
  - 6.2.6 Зөрчлийн талаар Хороонд мэдэгдэх;
  - 6.2.7 Гишүүнчлэлийн гэрээг цуцлах;
  - 6.2.8 Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах тухай саналыг үндэслэлийн хамт Хороонд хүргүүлэх;
  - 6.2.9 Гишүүн компанийн мэргэжилтний үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, цуцлах тухай саналыг үндэслэлийн хамт Хороонд хүргүүлэх.
- 6.3. Гишүүн компанийн холбогдох этгээдэд түүний охин компани, эрх бүхий албан тушаалтан, ажилтан, аудитор, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг хамааруулна.
- 6.4. Энэхүү журмын 6.2.1-6.2.6-д заасан хариуцлага тооцох шийдвэрийг Гүйцэтгэх захирал, 6.2.7-6.2.9-д заасан хариуцлага тооцох шийдвэрийг ТУЗ гаргана.
- 6.5. ТУЗ-ийн даргын олгосон зөвшөөрлийг үндэслэн ТУЗ-ийн хариуцлага тооцох эрхийг Гүйцэтгэх захиралд шилжүүлж болно.
- 6.6. Гишүүн компани зөрчлийг арилгах тухай Биржийн тавьсан шаардлага, албан даалгаврыг биелүүлэх үүрэгтэй.
- 6.7. "Бүртгэлийн журам"-д үнэт цаас гаргагчид хариуцлага тооцохоор заагаагүй бол энэхүү журмын 6.2-д заасан хариуцлагыг үнэт цаас гаргагчид тооцож болно.
- 6.8. Гишүүн компани хяналт шалгалт хийлгэхээс татгалзсан эсхүл шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд энэ бүлэгт заасан хариуцлага тооцохоос гадна уг шалгалтыг зохион байгуулахтай холбоотой бүх зардлыг гишүүн компани хариуцна.
- 6.9. Бирж гишүүн компанийн арилжаанд орох эрхийг түдгэлзүүлсэн эсхүл гишүүнчлэлийн гэрээг цуцалсан тохиолдолд Биржийн вэб сайтад энэ тухай мэдээллийг байршуулж олон нийтэд мэдэгдэнэ.
- 6.10. Энэ бүлэгт заасны дагуу гишүүн компанид хариуцлага тооцсон, гишүүнчлэлийн гэрээг цуцалснаас үүдэн гишүүн компанийн харилцагчид учирсан хохирлыг Бирж хариуцахгүй ба тухайн хохирлыг гишүүн компани бүрэн хариуцна.

- 6.11. Гишүүн компанийн гаргасан зөрчлийг хэлэлцэх зорилгоор ТУЗ, Биржийн Гүйцэтгэх захирал зөрчлийг хэлэлцэх хурал зарлаж болно. Хурлын үеэр гишүүн компани тухайн асуудлаар тайлбар хийх эрхтэй.
- 6.12. Бирж хариуцлага тооцох тухай шийдвэр гаргахдаа гишүүн компанийн тайлбарыг харгалзан үзэж болно. Гишүүн компани зөрчлийг хэлэлцэх хуралд оролцоогүй тохиолдолд хурлыг үргэлжлүүлж, холбогдох шийдвэрийг гаргана.
- 6.13. Бирж гишүүн компанид хариуцлага тооцох эрхээ хэрэгжүүлэхдээ шударга байх, бодит баримтад үндэслэх, гаднын нөлөөнд үл автах зарчим баримтална.
- 6.14. Бирж гишүүн компанид хариуцлага тооцсон шийдвэр гаргах бүр энэ тухай Хороонд мэдэгдэнэ.
- 6.15. Бирж гишүүнчлэл нь цуцлагдсан, эсвэл системд нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гишүүн компанийн нэрсийг өдөр тутмын сонин, хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдэгдэл, электрон болон бусад хэлбэрээр нийтлэх эрхтэй. Тухайн нийтлэлд дурдсан хариуцлагын талаар холбогдох гишүүн компани нь хэвлэн нийтлэх, тараах зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдийн эсрэг гомдол гаргах эрхгүй.
- 6.16. Биржийн гишүүнээс хасагдсан этгээдийн гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан дахин гишүүнээр элсүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.
- 6.17. Гишүүн компани нь Биржээс зарласан зөрчлийг хэлэлцэх хуралд өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулж болно.
- 6.18. Бирж зөрчлийг шалган тогтоох зорилгоор хуулийн зөвлөх үйлчилгээ авч болох бөгөөд гишүүн компанийн буруутай нь тогтоогдвол зөвлөх үйлчилгээний зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэх эрхтэй.
- 6.19. Гишүүн компанийн гишүүнчлэл эсвэл системд нэвтрэх эрхийг аливаа шалтгаанаар түдгэлзүүлсэн тохиолдолд:
  - 6.19.1. Гишүүнчлэл эсвэл системд нэвтрэх эрх нь түдгэлзсэн гишүүн компани төлбөрийн баталгааны санд хийх мөнгөн дүн, мөн энэхүү журмаар тогтоосон аливаа төлөгдөөгүй төлбөр хураамжийг төлж барагдуулах үүрэг хүлээсэн хэвээр байна.
  - 6.19.2. Гишүүн компанийн арилжаанд оролцох, харилцагчийн захиалгыг Биржид дамжуулах эрхийг түдгэлзүүлэх бөгөөд уг түдгэлзүүлсэн хугацаанд шууд болон шууд бусаар арилжаанд оролцохыг ТУЗ эсвэл Гүйцэтгэх захирлын зөвшөөрснөөс бусад тохиолдолд хориглоно.
  - 6.19.3. Гишүүн компанийн арилжаанд оролцох эрх эсвэл гишүүнчлэлийг түдгэлзүүлэхээс өмнө харилцагчаас захиалга авсан тохиолдолд уг захиалгыг биелүүлэхээр өөр гишүүн компанийг өөрийн төлөөлөл болгон томилно.
- 6.20. Гишүүн компанийн эрхийг цуцалсан тохиолдолд Биржийн арилжаанд оролцох бүх эрх мөн адил хүчингүй болно.
- 6.21. Гишүүн компанийн эрхийг аливаа шалтгаанаар цуцалсан тохиолдолд эрх цуцлагдсан өдрөөс эхлэн ТУЗ уг гишүүн компанийн үнэт цаас арилжаалах эрхийг цуцална. Эрхийг цуцалсны дараа гишүүн компанийг Биржийн үнэт цаас арилжаалах эрх эзэмшигчийн жагсаалтаас хасна. Энэхүү журмын дагуу гишүүн компанийн арилжаанд оролцох эрхтэй холбогдуулан Бирж үүрэг хүлээхгүй.
- 6.22. Энэ журмын 6.20, 6.21-ийн дагуу тус тус гишүүн компанийн эрх болон арилжаанд оролцох эрхийг цуцалсан тохиолдолд холбогдох гишүүн компани нь Биржид төлөх хураамж, өмгөөлөл болон бусад гэнэтийн зардалд хариуцлага үүлээсэн үзвээр байна.
- 6.23. ТУЗ-ийн гаргасан шийдвэр эцсийн шийдвэр бөгөөд уг шийдвэрийн хэрэгжилтийг хойшлуулах, бусад эрх бүхий этгээд, байгууллага өөрчлөхийг хориглоно.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ**

- 7.1. Үнэт цаас гаргагч болон гишүүн компанитай холбоотой иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг Бирж өөрийн эрх мэдлийн хүрээнд шалгаж, шийдвэрлэнэ.
- 7.2. Хэрэв иргэд, байгууллагын гаргасан өргөдөл, гомдол нь Биржийн чиг үүрэгтэй хамааралгүй бол өргөдөл, гомдлыг буцаах буюу Биржийн эрх, үүргийн хэмжээнээс хэтэрсэн бол Хороо болон бусад холбогдох байгууллагад шилжүүлнэ.
- 7.3. Иргэд, байгууллагаас өргөдөл, гомдол ирсэн тохиолдолд өргөдөл, гомдлын хуулбарыг холбогдох үнэт цаас гаргагч болон гишүүн компанид хүргүүлнэ. Өргөдөл, гомдол ирүүлсэн этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд өргөдөл, гомдлын хуулбарыг гишүүн компанид өгөхгүйгээр өргөдөл, гомдол ирүүлсэн этгээдийн нэр, өргөдөл, гомдлын товч агуулгыг танилцуулсны үндсэн дээр хяналт, шалгалтыг гишүүн компанид хийж болно.
- 7.4. Бирж өргөдөл, гомдол гаргасан иргэн, байгууллагад хуульд заасан хугацаанд багтаан хариуг бичгээр хүргүүлнэ.
- 7.5. Өргөдөл, гомдолтой холбоотойгоор энэхүү журамд заасны дагуу хяналт, шалгалт хийсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг өргөдөл, гомдол гаргагчид хүргүүлнэ.

**НАЙМДУГААР БҮЛЭГ**  
**МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 8.1. Энэхүү журмын 6.2.1-6.2.6-д заасан хариуцлагыг тооцсон Гүйцэтгэх захирлын шийдвэрийг хариуцлага хүлээсэн этгээд эс зөвшөөрвөл шийдвэр гарснаас хойш ажлын 5 (тав) хоногийн дотор ТУЗ-д гомдол гаргаж болно. ТУЗ гомдлыг шийдвэрлэх журмыг батална.
- 8.2. Энэхүү журмын 6.2.7-6.2.9-д заасан хариуцлагыг тооцсон ТУЗ-ийн шийдвэрийг хариуцлага хүлээсэн этгээд эс зөвшөөрвөл шийдвэр гарснаас хойш ажлын 10 (арав) хоногийн дотор Хорооны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.